

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/, Стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал:

- ❖ Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график
- ❖ Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийж фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг хийлгэсэн байна.

Барилгын засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 1 дүгээр давхарын ариун цэврийн өрөөний их засварын ажлыг гүйцэтгэнэ. Дээрхи ажлыг гүйцэтгэхдээ батлагдсан зураг төсөл (Зураг төслийн ЕГ Шифр: АЕС-01/23), мөн стандарт, технологийн дагуу хийж гүйцэтгэж ашиглалтанд оруулна.

Сургуулийн 1 дүгээр давхарын ариун цэврийн өрөөний засварын ажилд:

1. Буулгах ажил,
2. Дотор засвар,
3. Дотор гэрэлтүүлэг, агаар сэлгэлтийн ажил,
4. Цэвэр, бохир усны ажил,
5. Бусад ажил /тавилга хийх/,

*Барилгын угсралтын ажил гүйцэтгэх явцад барьцалдуулах зуурмаг, шавардлага зэрэгт туршилт, сорилт, хяналт шалгалтыг талбай дээр ажлыг хийж гүйцэтгэж байх хугацаанд байвал зохино. Барилгад бүх материал нь улсын стандартад нийцсэн материал сонгосон байх шаардалагатай.*

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна” гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

*Барилгын засварын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ.*


Магадлашгүй ажлыг хэрхэн, ямар ажилд зарцуулах талаар Захиалагчийг төлөөлж техник хяналт хэрэгжүүлж байгаа байгууллага болон хяналтын инженер танилцуулж, шийдвэрийг Захиалагч буюу аймгийн ЗДТГ, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс гаргана. Зөвшөлцөөгүй, танилцуулаагүй, хянагдаагүй тохиолдолд магадлашгүй ажлын зардлыг санхүүжүүлэхгүй болно.

Засварын ажлын зураг төслийн зардал болох 14,000,000 /арван дөрвөн сая/ төгрөгийг тооцож ирүүлнэ.

Дээрхи техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Боловсруулсан:

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн



Ж.Батсуурь